



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

О.Түвшиндэмбэрэлийг ажлаас чөлөөлж,
төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйл, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал О.Түвшиндэмбэрэл ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлж, түүнтэй байгуулсан контрактыг цуцалсугай.

2.“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал томилогдох хүртэл захирлын үүргийг гүйцэтгэх төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Удирдлага, төлөөллийн албаны дарга В.Дарханбаатарыг түр томилсугай.

3.О.Түвшиндэмбэрэлтэй холбогдох тооцоо хийж, тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-эрдэнэ)-т, “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий нягтлан бодогч Г.Төрбат нарт даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132901412